

Unlocking Blocks

Үхэрнүүд оньс тайлах маш их дуртай! Бэссигийн төрсөн өдрөөр Фермер Жон түүнд сонирхолтой оньс бэлэглэхээр

шийджээ. Оньс нь 1×1 хэмжээтэй квадратуудыг наасан гурван бүхэл дүрсээс бүтнэ. Энэ гурван дүрс нь “холбогдсон”

байх бөгөөд аль нэг дүрсийг баруун, зүүн, дээш, доош зүгүүд рүү хөдөлгөж болно.

Дүрсүүдийг олон дахин хөдөлгөж хооронд холбогдоогүй буюу хөрш талгүй болгох нь таны зорилго юм.

Та гурван дүрсийн байрлалыг мэдэж байгаа бол оньсыг тайлж болох үгүйг олно уу.

[Жич: Дурын байдлаар хариу гаргадаг програмуудыг тооцохгүй бөгөөд, оноо өгөхгүй]

ОРОЛТ

Эхний мөрөнд дүрс бүрийн хэдэн квадратуудаас бүтэхийг илэрхийлсэн N_1, N_2, N_3 бүхэл тоонууд өгөгдөнө.

Дараагийн N_1 мөрөнд эхний дүрсийн квадратын координат болох (x, y) бүхэл тоонууд мөр тус бүрт өгөгдөнө. ($0 \leq x, y \leq 9$)

Дараагийн N_2 мөрөнд хоёр дахь дүрсийн квадратын координат болох (x, y) бүхэл тоонууд мөр тус бүрт өгөгдөнө. ($0 \leq x, y \leq 9$)

Дараагийн N_3 мөрөнд гурав дахь дүрсийн квадратын координат болох (x, y) бүхэл тоонууд мөр тус бүрт өгөгдөнө. ($0 \leq x, y \leq 9$)

ЖИШЭЭ ОРОЛТ

12 3 5

0 0

1 0

2 0

3 0

3 1

0 1

0 2

0 3

0 4

1 4

2 4

3 4

2 1

2 2

1 2

2 3

3 3

4 3

4 4

4 2

ОРОЛТЫН ТАЙЛБАР

Эхний дүрс 12 нүднээс, 2 дахь дүрс 3 нүднээс, 3 дахь дүрс 5 нүднээс тогтоно. (x,y) координат нь зүүн доороос тоолно.

ГАРАЛТ

Хэрэв оньсыг тайлах боломжтой бол 1 үгүй бол 0 гэж хэвлэнэ.

ЖИШЭЭ ГАРАЛТ

1

[Brian Dean, 2012]

Орчуулсан : УБ 1-р сургуулийн 12-р ангийн сурагч Б.Мөнх-Оргил

